

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН MV-020772 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААРТАЙ “ХӨӨТИЙН ХОНХОР-2” НЭРТЭЙ НҮҮРСНИЙ УУРХАЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



БҮЛЭГ 1. НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг: “Биг могул коул энд энержи” ХХК, Улсын бүртгэлийн дугаар-9011665117, регистрийн дугаар-5369223.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Центрум оффис, 4 давхар 401 тоот.

1.2. Ордын байршил

Ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын Энгэр-Ус багийн нутагт нийт 1046.73 га талбайг хамран оршдог. Улаанбаатар хотоос 340 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн урагш 130 км, Баянжаргалан сумаас 25 км, Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай авто замаас 90 км зайд тус тус байрлана.

1.3. Ордын нөөц

“Хөөтийн хонхор-2” нүүрсний ордын нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын бүртгэлд 2014 онд бүртгүүлж 2017 оноос олборлолтын үйл ажиллагааг явуулж эхэлсэн байна. Ордын хэмжээнд нөөцийг цэврээр:

- Бодиттой В зэргээр - 7,189.31 мян.тн;
- Боломжтой С зэргээр - 11,001.90 мян.тн;
- Нийт В+С нөөц 18,191.21 мян.тн тооцоолсон.

Ордын нийт нөөцийн 40.8%-ийг Д-3, 49.18%-ийг Д-2, 10.02%-ийг Д-1 давхраас эзэлж байна. 2017-2022 он хүртэл бодитой (В) зэргээр 626.47 мян.тн, боломжтой (С) зэргээр 123.96 мян.тн нүүрсийг тус тус олборлож ашиглалтын үйл ажиллагааны тайлангаар баталгаажуулсан байна.

1.4. Уурхайн хүчин чадал, техник, технологи

“Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний ордыг 9 жилийн хугацаанд ашиглана. Ашиглалтын нийт хугацаанд 41743,4 мян.м3 уулын ажил, 17431,3 мян.м3 хөрс хуулалт, 100,2 мянган м3 шимт хөрс хуулалт хийж 8749 мянган тонн нүүрс олборлохоор төлөвлөсөн. Нийт 96.3 га талбай ухаш, овоолго, зам, бусад байдлаар эвдрэлд өртөх бөгөөд 100,2 мян.м3 шимт хөрс хуулан шимт хөрсний овоолгод овоолно. Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллаж жилд 1,000 мян.тн нүүрс олборлоно.

Ашиглалтын систем: Ордын талбайн нөөцийн нүүрсний давхраасууд нь газрын гадаргууд харьцангуй ойр тул ил уурхайн аргаар авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр олборлох бөгөөд хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ - ухаж ачих ажиллагаа - автотээвэр - гадаад овоолго гэсэн дарааллаар гүйцэтгэнэ.

Төслийн хугацаанд 8.75 сая тонн нүүрсийг борлуулж, 393.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олохоор тооцсон байна. Улсын болон орон нутгийн төсөвт жил бүр 9.1-10.6 тэрбум төгрөгийг татвар төлбөрийн хэлбэрээр оруулна. Төслийн хугацаанд энэ нь 84.1 тэрбум төгрөг, үүнээс улсын төсөвт 46.0 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 38.1 тэрбум

төгрөг оруулахаар болж байгаа нь нийт борлуулалтын орлогын 21.4%-тай тэнцэнэ. Уурхайн ашиглалтын хугацаанд жил бүр 160 сая төгрөгийг тухайн орон нутгийг хөгжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 1. Ил уурхайн календарчилсан төлөвлөлт

Ашиглалтын жил	Нүүрс, тн	Шимт хөрс, м3	Хучаас хөрс, м3	Нийт хуулах хөрс, м3	Кхх, м3/тн
1	1,000,000	37,506	3,200,527.29	3,238,033.29	3.24
2	1,000,000	23,257	2,167,149.35	2,190,406.35	2.19
3	1,000,000	39,469	2,912,899.45	2,952,368.45	2.95
4	1,000,000		2,349,632.35	2,349,632.35	2.35
5	1,000,000		2,588,315.26	2,588,315.26	2.59
6	1,000,000		2,135,863.20	2,135,863.20	2.14
7	1,000,000		878,998.10	878,998.10	0.88
8	1,000,000		699,627.01	699,627.01	0.70
9	749,211		498,419.00	498,419.00	0.67
Нийт	8,749,211	100,232	17,431,431	17,531,663.01	2.00

1.5. Техник, тоног төхөөрөмж

“Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах бөгөөд жилд 1,000 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтай байна. Ил уурхайн олборлолтод олон салаа үетэй нүүрс олборлох тул компанийн ашиглаж буй Hyundai R2900LC маркийн 1.1 м3 шанаганы багтаамжтай экскаваторыг нимгэн нүүрсний үеүд, Hyundai R500LC маркийн 3.2 м3 шанаганы багтаамжтай экскаваторыг нүүрсний зузаан үеүдэд олборлолтын ажил явуулна.

Хүснэгт 2. Төсөлд ашиглаж буй техникийн жагсаалт

Хүснэгт-	Техникууд	Хүчин чадал	Тайлбар
1	Экскаватор, Hyundai R500LC, м3	3.2	Түрээс
2	Экскаватор, Doosan 800, м3	3.2	Түрээс
3	Экскаватор, Doosan 500, м3	3.2	Түрээс
4	Экскаватор, Hyundai R520LC, м3	3.2	Түрээс
5	Экскаватор, Hyundai R2900LC, м3	1.1	Түрээс
6	Экскаватор, Hyundai R3000LC, м3	1.1	Түрээс
7	Автосамосвал, Howo, тн	60	Түрээс
8	Автосамосвал, Hoteo, тн	20	Өөрийн
9	Утгуурт ачигч, Liungong, м3	3	Түрээс
10	Утгуурт ачигч, XCMG, м3	3	Түрээс
11	Бульдозер, Shantui SD16, м3	8.7	Түрээс

Хүснэгт 3. Технологийн процессын тоног төхөөрөмжүүдийн ажиллах горим

№	Процессын нэр	Тоног төхөөрөмж	Ажлын горим
1	Тэсэлгээний цооног өрөмдлөг	Өрмийн машин	Хоногт 1 ээлж
2	Хөрс, нүүрс ухаж ачих	Экскаватор	Хоногт 2 ээлж
3	Хөрс, нүүрс тээвэрлэлт	Автосамосвал	Хоногт 2 ээлж
4	Хөрсний овоолго	Бульдозер	Хоногт 2 ээлж
5	Нүүрсний түр овоолго	Утгуурт ачигч	Хоногт 1 ээлж

1.6. Уурхайн дэд бүтэц

Гадаад тээврийн зам: “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхайгаас Чойрын өртөө хүртэл 130 км зайтай. Тус 130 км автозамыг аж ахуй нэгжүүд хуваан авч сайжруулсан шороон замыг барьсан бөгөөд байнгын арчилгаа, засварын ажлын гүйцэтгэж байна. Мөн тухайн нүүрс тээвэрлэгч аж ахуй нэгжүүд 1 автомашинаас 15,000 төгрөгийн хураамжыг улсын төсөвт төлдөг.

Дотоод тээврийн зам: Ил уурхайн хөрс тээвэрлэлтэд БНХАУ-ын 60 тн даацтай МТ86 маркийн автосамосвал, нүүрсний тээвэрлэлтэд 20 тн даацтай Howo маркийн автосамосвал ажиллуулдаг. Ил уурхайгаас олборлосон нүүрсийг автосамосвалаар тээвэрлэн ил уурхайгаас баруун хойд зүгт байрлах нүүрсний агуулахад буулгах ба нүүрс тээвэрлэлтийн хамгийн их зай хамгийн 2 км байна. Хөрсийг ил уурхайн хойд, зүүн урд талд байрлах хөрсний гадаад овоолгод тээвэрлэн овоолох ба хөрс тээвэрлэлтийн хамгийн их зай 2 км байна.

Засвар, техникийн үйлчилгээний газар: Нүүрсний уурхайн засвар, техникийн үйлчилгээний газар нь уул, үйлдвэрийн машин техник, тоног төхөөрөмж, автотээврийн болон туслах тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийхийн зэрэгцээ засвар ашиглалтын хэрэгцээний төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, түлш, тос зэргийг хүлээн авч хадгалах, тавьж олгох зориулалттай байна. Засварын цехт 6 хүн ажиллана.

Тэсрэх материалын агуулах: Уурхайн тэсэлгээг гэрээт мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй компаниар гүйцэтгүүлэх бөгөөд ингэснээр нэмэлт тэсрэх материал агуулах барих, тэсрэх бодис тээвэрлэх ажил үйлчилгээг хөнгөвчлөх боломжтой.

Шатах тослох материалын агуулах: Түлш хадгалах зориулалтаар 50 тонны багтаамжтай ган сав 1 ширхэгийг, дизелийн масло болон бусад тос материалыг зориулалтын савтай нь төмөр чингэлэгт тус тус хадгалах юм.

Усан хангамж: Уурхайн ашиглалтын үед унд ахуйн усны хэрэгцээг тусгай зөвшөөрлийн талбайд гаргасан 1.1 л/с ундаргатай гүний худгаас хангана.

Цахилгаан хангамж: “Хөөтийн хонхор-2” уурхайн ойролцоо “МАК” ХХК-ийн татсан 35/10 кВ-ын өндөр хүчдлийн шугамд холбогдсон байдаг. Төслийн хугацаанд “МАК” ХХК-тай гэрээ хэлэлцээр хийж уг өндөр хүчдлээс хангах боломжтой юм. Өнөөдрийн байдлаар тус уурхай нь цахилгаан хангамжийг цахилгаан дизель үүсгүүр ашиглан хангаж байна. Уурхайн цахилгаан хэрэглэгчид нь ил уурхайн тоног төхөөрөмжийн ажлын байрны гэрэлтүүлэг болон уурхайн хотхон, уурхайн засвар механикийн цехээс бүрдэнэ.

БҮЛЭГ 2. ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ОНЦЛОГ

2.1. Бүс нутгийн газарзүй

Орд газар нь физик газар зүйн хувьд ухаа гүвээт талын хэв шинжид багтах ба Дундговь аймгийн Говь-Угтаал, Гурвансайхан, Баянжаргалан сумдын нутгийн заагт буй баруун талаараа Баруун хүрийн ухаа, зүүн талаараа Талын хоолой, Талын худгийн хөндий, хойт талаараа Хар хадны толгодоор хүрээлэгдсэн Сүүдрийн хоолойн дунд буй Хөөтийн булаг орчимд оршино. Хөндийн зах орчмоор нь Хөөтийн толгод, Хар тэвш уул зэрэг жижиг толгодуудтай ажээ. Баянжаргалангийн хотгорыг хүрээлэн буй уулсын хэцийн хамгийн өндөр нь 1438 м өргөгдсөн Хавирга уул, 1316 м өргөгдсөн Ухаа тээг уул, 1222 м өргөгдсөн Сүүл толгой, 1279 м өргөгдсөн Бага хонгор уул, 1265.3 м өргөгдсөн Хар тэвш уулууд байна. Ордын дүүргийн газрын гадаргуу нь хойноос урагшаага хэвгий бөгөөд хотгорын хойт хэсэгт далайн төвшингөөс дээш 1300 м өргөгдсөн байхад ордын орчимд 1200 м болон намссан байна.

Зураг 1. MV-020772 тусгай зөвшөөрөлтэй талбайн сансраас харагдах байдал



2.2. Гадаргын болон газрын доорх усны судлагдсан байдал, усан хангамж

Гадаргын ус: Энэ бүс нутаг ус зүйн хувьд газар доорх усны нөөц зонхилсон “Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар”-т хамаарах бөгөөд гадаргын усны жилийн дундаж нөөц 0.25 км³ байдаг нь нэн бага хэмжээ юм. Ордын талбайн хэмжээнд тогтмол урсгал ус байхгүй харин зуны улирлын сүүлч, намраар үргэлжилсэн ширүүн борооны дараа хөндий, хуурай сайруудаар хэмхдэс чулуулаг зөөвөрлөсөн түр зуурын булингартай үерийн ус урсдаг. Нутаг дэвсгэрийн хүрээнд худаг, шанд харьцангуйгаар нэлээд элбэг. Худгийн усны нөөц тогтоогдоогүй, ундарга нь 0.2-0.8 л/сек. Үүнээс гадна хүн, малын ундаанд удаан хугацаагаар хэрэглээгүй дарагдсан буюу усгүй худаг, шанднууд ч нэлээд тааралдана. Гэвч эдгээрийн ихэнх

нь эрдэсжилт ихтэй тул ундны болон техникийн хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй юм. Төслийн талбайд болон талбайн 200м-н радиуст гадаргын усны эх үүсвэр байхгүй байна.

Хөөтийн булаг: Хөөтийн булаг нь малын унданд их хэрэглэдэг булаг юм. Энэ булаг нь 300м орчим урсдаг бөгөөд хур тунадас орсон, ус элбэгтэй үед 800-1000м урсаад шургадаг байна. Голдрилын өргөн 0.5-1.0м. Хээрийн судалгааны үед Хөөтийн булгийн зарцуулгыг хөвүүрийн аргаар хэмжихэд 0.07 м/ сек байв. Хөөтийн булаг нь жилийн дөрвөн улиралд устай байх боловч цаг уур хуурайших тутамд ус нь татарч багассаар хатдаг байна.

Хүснэгт 4. Хөөтийн булгийн харагдах байдал



Нүүрсний ордын гидрогеологийн нөхцөл: Хөөтийн хонхор ордын давхарга зүйн ангиллыг доод цэрдийн элсэн чулуу, алевролит, шатдаг занар, дээд юрийн конгломерат, элсэн чулуу, элс, нүүрс зэргээс бүрдэж буй гэж ангилсан байна. Хайгуулд хамрагдсан талбайн хэмжээнд тархсан терриген гаралтай конгломератын зузаалаг нь баруунаас зүүн тийш нимгэрэх буюу литологийн бүтэц жижиг ширхэгт хурдсанд аажмаар шилжиж байна.

Хүснэгт 5. Ордын гидрогеологийн үндсэн үзүүлэлт

Цооног дугаар	Ус илэрсэн гүн, м	Тогтсон түвшин, м	Уст үеийн зузаан, м	Ус агуулагч чулуулгийн тодорхойлолт
Н-1	10.0	10.0	38.0	Элсэн чулуу, гравелитын салаавчилсан үе
Н-2	12.0	7.0	34.4	Элсэн чулуу, аргиллит, нүүрс, салаавчилсан үе
Н-3	12.0	11.0	-	Нурсан, гүн-27.0 м
Н-2А	12.7	7.0	34.4	Элсэн чулуу, аргиллит, нүүрс, салаавчилсан үе

Төслийн усан хангамж: Нүүрсний ил уурхайн унд ахуйн усны хэрэглээг уурхайн талбайд байрлах 1.1 л/с ундаргатай гүний худгаас хангана. Төслийн ус ашиглалтын тооцооллоос харахад унд ахуйн ус хэрэглээг гүний худгийн уснаас, уурхайн өрөмдлөгийн ажлын усны хэрэглээг уурхайн шүүрлийн уснаас хангахад хүрэлцээтэй байна. Гүний худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн, сул хүчиллэг орчинтой шүүсэн ус байна. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ “MNS 0900:2018” стандартад нийцэж байна.

Зураг 2. Ус хангамжийн худаг



2.3. Хөрс, ургамлан бүрхэвч

Монгол орны байгалийн бүс бүслүүрийн хувьд цөлжүү хээрийн бүс нутагт орших бөгөөд цайвар хүрэн хөрс, хүрэн хөрс зонхилох бөгөөд хөрсний дундаж зузаан нь 10-20 см байна. Ургамалжилтын хувьд цөлжүү хээрийн ургамалжилтай. Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дундад халхын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Энэ тойрогт 793 зүйл ургамалтай бөгөөд зөвхөн энэ тойрогт ургадаг 1 зүйл (*Papaver rubro-aurantiacum*)ийн ургамалтай. Дундад Халхын тойргийн үндсэн төрхийг үзүүлэх зүйлүүд: Жижигнавчит харгана (*Saragana microphylla*), Япон хайлас (*Ulmus pumila*), Бариулт бүйлэс (*Amygdalus pedunculata*), Дэрэвгэр тарна (*Polygonum divaricatum*), Дорнодын хамхуул (*Corispermum orientale*), Дэрвээн цульхир (*Agriophyllum pungens*), Монгол хамхуул (*Corispermum mongolicum*), Услиг мананхамхаг (*Bassia dasphylla*), Козловын сүүт-өвс (*Euphorbia kozlovii*), Сибирь шорной (*Atriplex sibirica*), Эрлийз лууль (*Chenopodium hybridum*), Клеменцийн ортууз (*Oxytropis klementzii*), Хангайн шарилж (*Artemisia changaica*), Толгодын багваахай (*Taraxacum collinum*) зэрэг болно.

2.4. Амьтны аймаг

Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Төвдийн муж, Монгол дагуурын хээрийн дэд муж, Монгол дагуурын хээрийн тойргийн урд зах Дорноговийн хээрийн тойргийн хойд захад хамаарна. Монгол дагуурын хээрийн тойрогт жижиг хөхтнөөс үлийн цагаан оготно, дагуур огдой, дагуурын зурам, монгол чичүүл, туруутнаас аргаль хонь, янгир ямаа, цагаан зээр, мах идэшт амьтдаас хотны үен, өмхий хүрнэ, хярс үнэг, шар үнэг зонхилно (Банников, 1954). Монгол дагуурын хээрийн тойргын амьтны зүйлийн бүрэлдэхүүн, оршин амьдрах хэлбэр, зарим зонхилгогч зүйл амьтдын биологи экологийн нарийвчилсан судалгааны дүнд 4 багийн, 14 овгийн, 54 зүйлийн шавж (Murdoch et al., 2006); 1 баг, 4 овгийн 7 зүйл

мөлхөгч (Reading et al., 2006a); 14 баг 30 овог, 185 зүйлийн шувуу (Reading et al., 2011); 7 баг 15 овог 28 төрөлд хамаарах 39 зүйлийн хөхтнийг тэмдэглэсэн байдаг (Reading et al., 2013 in press).

2.5. Нийгэм эдийн засгийн судалгаа

“Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхай нь Энгэр-Ус II-р багийн нутагт үйл ажиллагаа явуулдаг. Тус баг нь 161 өрхийн 467 хүн амтай. Тусгай зөвшөөрлийн талбайн орчин нь хүн амын суурьшлын хувьд сийрэг, 1 км² нутагт 0.5-1.0 хүн ноогдох ба нутгийн иргэд нь гол төлөв мал аж ахуй эрхэлж байна. Орон нутгийн удирдлага, иргэдийн төлөөлөлтэй хамтран ажиллах хүрээнд жил тутам 160 сая төгрөгийн хандив тусламж үзүүлэхээр төлөвлөсөн байна. Энэ хөрөнгийг нутгийн удирдлагатай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулна.

2.6. ТХГН, Төслөөс түүх, соёлын дурсгалт зүйлс

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт манай эриний өмнөх хүрэл чулуун зэвсгийн үеийн дурсгалын нэг чухал сэдэв болох хадны зураг, бичээс, хүн малын мөр, сүг зураг түгээмэл байдаг. Сэрвэн шар ганга зэрэг байгалийн сонин тогтоцтой газрууд бий. 16-р зууны үеийн халх Өөлдийн ширүүн тулалдаан тус сумын нутагт болж байсныг гэрчлэх өндөрлөг газар, чулуун харуул хамгаалалт Саруулын болон Буурлын бичигт хад, могойн талын чулуун хэрэм, Зараа, Баянцогтын булш хиргэсгүүрүүд бий.

Ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний ордыг ашиглах явцад газар дээр ил ямар нэн таних тэмдэггүй булш, хүний үйл ажиллагааны ул мөрүүд тохиолдох магадлалтай тул хөрс хуулалтын үед хүн, малын яс, ваар сав, төмөр эдлэл болон бусад төрлийн эд өлгийн зүйлс илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэх шаардлагатай.

БҮЛЭГ 3. ГУРАВ. ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ БА ГОЛ ШААРДЛАГА

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиар тухайн төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагааныхаа хүрээнд төсөл хэрэгжих орчны нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам /БОАЖЯ/-аар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээхээр зохицуулсан.

Хуульд БОАЖЯ нь тухайн төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгож, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр/-өөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө,

зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

“Биг могул коул энд энерги” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “Биг могул коул энд энерги” ХХК нь байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хувиарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан. Мөн БОАЖЯ нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл болон тус хуулийн 9.12-т зааснаар хянуулсан хяналтын дүнд хөндлөнгийн хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулах бөгөөд уг дүгнэлт, төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг үндэслэн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг энэ тухайн хуулийн 9.5-д заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын дагуу шийдвэрлэх юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

БҮЛЭГ 4. ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДСЭН ЗОРИЛТУУД, ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийн хүрээнд “Биг могул коул энд энерги” ХХК-ийн дагаж мөрдөн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Майндата” ХХК-ийн боловсруулсан Хөөтийн хонхор-2 нүүрсний ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-ийн тодотгол болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээчийн 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 12/1812 дугаартай Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр өгсөн чиглэл болон өмнө хийгдсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсрууллаа.

Мөн 2012 оны 5 дугаар сард УИХ-р хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай, Ургамал хамгааллын тухай,

Амьтны тухай, Агаарын тухай, 2017 оны 5-р сард батлагдсан Хог хаягдлын тухай хууль болон түүнтэй холбогдсон бусад хуулиудад орсон өөрчлөлтүүд ялангуяа аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах талаар хүлээх үүргийг тусгасан болно.

Төсөл хэрэгжүүлэгч “Биг могул коул энд энерги” ХХК нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланд тусгагдсан зөвлөмж, нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/-г төслийн бүх үе шатанд дагаж мөрдөн ажиллах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт:

Төсөл хэрэгжиж буй орон нутгийн малчин иргэдийн нутагшил нийгэм, эдийн засгийн байдалд болон түүх соёлын үнэт зүйлсэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах;

Үйл ажиллагааны явцад төсөл хэрэгжих орчны нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг хянаж, илрүүлж гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад уг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт оршино.

БҮЛЭГ 5. ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардалыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу “Биг могул коул энд энерги” ХХК-ийн ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг төслийн хүчин чадлыг өргөтгөх, өөрчлөх бүрд нэмэлт тодотгол хийж байх шаардлагатай бөгөөд 2024 оноос хойш 5 жилийн дараа буюу 2028 оны төгсгөлд төслийн үйл ажиллагаа, энэхүү төлөвлөгөөний болон жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны явцад хийсэн дотоод болон хөндлөнгийн аудитын дүн, нүүрс олборлох үйл ажиллагааны өөрчлөлттэй уялдуулан дахин 5 жилээр хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагаар батлуулах шаардлага тавигдана.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай.

5.1. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах									
1	Үйл ажиллагааны явцад тоосжилт үүсч агаарын чанарыг бага хэмжээгээр доройтуулна	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох	Уурхайн ашиглалтын талбайн тоос үүсгэх гадаргуу	-	800.0		800.0		ЗТБХБ-ын сайдын 2011 оны 216 тоот тушаал. MNS4585:2007
2		Уурхайн ачиж буулгах талбай болон дотоод замыг услах, хөрс барьцалдуулагч шингэнээр шүрших (CaCl, MgCl-н хольц, FLOSET SR71 г.м) туршилт судалгаа хийх	Уурхайн дотоод тээврийн зам овоолгууд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	
4		Хүнд механизм утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах талаар засвар үйлчилгээг тогтмол явуулах. (бусад уурхайн жишгийн дагуу 200 мото/цаг) Хөдөлгүүрээс гарах утааны найрлага стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд шүүлтүүр, гүйцэд исэлдүүлэх хэрэгсэл төхөөрөмж тавих /TWCAT002,	Төслийн хүрээнд, уурхайд ажиллаж буй бүх хүнд механизмуудад	Ширхэг	400.0	-	400.0	2024 он	MNS5885:2008 MNS 5013:2009 MNS 5014:2009 MNS 5919:2008

Дунговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
5		Уурхайн хотхонд байрлах уурын зуухны янданд шүүлтүүр суурилуулах	Уурын зуух	Ширхэг	-		100.0	2024 он	
7		Уурхайн талбайд ажиллах авто тээврийн хэрэгслийн хурдыг /40км/ боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Төслийн хүрээнд	-	-	-	-	2024 он	
		Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачиж буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторх агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх	Төслийн хүрээнд, уурхайн ажиллаж буй бүх машин техникүүдэд	-	500.0	-	500.0	2024 он	ХАБЭАТ хууль
8		Уурхай дотор замыг тэмдэгжүүлж, засаж сайжруулж байх	Төслийн хүрээнд	Ширхэг	200.0		200.0	2024 он	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2016
9		Замын ачааллын хяналтыг тэнцвэржүүлэх. Шороон замаар зорчих ачааны, автомашинуудын хоорондын зайг 20 секундээс 30 м-с их байхаар хугацаа болон хоорондох зайг тогтоох.	Төслийн дотоод тээврийн зам	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
10		Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, тэдэнд сургалт, сурталчилгаа явуулах	Уурхайн бүх ажилчдад	-	-	-	ХАБЭА-н зардлаас	2024 он	MNS 5080:2023 MNS 6768 : 2019 MNS 0012- 13:91
11	Орчны бохирдол, хөрс, ургамал, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл багасна	Уурхайн гадаад тээврийн замыг хатуу хучилттай болгох чиглэлээр шат дараалалтай арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллах/Ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжтэй хамтрах /	Гадаад тээврийн зам	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоол
13		Нүүрс ачсан бүх тээврийн хэрэгсэл ачааны хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр анхаарч, шаардлага тавьж ажиллах	Тээвэрлэлт хийж буй бүх тээврийн хэрэгслүүдэд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	
2. Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах									
14	Хөрс элэгдэл								MNS 5916:2008
15	эвдрэлд орох, үржил шим, чийг буурах,	Шинээр эвдрэлд өртөх талбайн шимт хөрснийг 20-25 см зузаан	Төслийн хүрээнд,	-	-	-		2024 он	

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
	бохирдох, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	тайгаар хуулж овоолгод хадгалах	Уурхайн эдэлбэр газарт				Үйд ажиллагааны зардал	Шинээр талбай эвдрэх бүрд	
16		Шимт хөрсийг нөхөн сэргээлтэд ашиглахгүй 2 жилээс дээш хугацаагаар хадгалах бол -ургамалжуулах	Уурхайн эдэлбэр дэх овоолгуудад	-		-		2024 он	
17		ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирлогдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах	Уурхайн эдэлбэрт хяналт тавих	-	500.0	-	500.0	2024 он Асгарч алдсан тохиолдолд тухай бүрд	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль, Газрын тухай хууль MNS 3307:1991, MNS 3308:1991
18		Машин механизмын засвар үйлчилгээг тусгай зориулалтын талбайд хийх, хучилт хийх, урсгал засварыг тогтмол гүйцэтгэх Ахуйн хатуу, шингэн хог хаягдал болон химийн бодисыг эмх цэгцтэй хадгалах, устгах, зайлуулах, тогтмол хяналт тавьж ажиллах	Уурхайн засварын талбайд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	
20		Уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллах	Уурхайн ашиглалтыг тогтворжуулах				Үйл ажиллагааны зардал	2024 он	

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
21		Уурхайн үйл ажиллагаанаас хөндөгдсөн газарт мониторинг хийж холбогдох арга хэмжээг тухай бүр авах	Дотоод хяналтыг сайжруулна				Үйл ажиллагааны зардал	2024 он	
Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах									
22	Төсөл хэрэгжиж буй талбайн газрын доорх усны нөөц хомсдох	Уурхайн шүүрлийн ус болон уурхайн унд ахуйд хэрэглэж буй гүний худгаас тогтмол хугацаанд дээж авч бохирдлыг хянах, зохих стандартад заасан ЗДХэмжээнээс давсан тохиолдолд зохих арга хэмжээнүүдийг жил бүрийн БОМТөлөвлөгөөнд тусган сөрөг нөлөөллийн эх үүсвэрийг арилгах, таслан зогсоох ажлыг тогтмол авч хэрэгжүүлж ажиллах	Уурхайн шүүрлийн ус болон уурхайн унд ахуйд хэрэглэж буй гүний худга	-	-	-	ОХШХ-ийн дагуу	2024 он	Усны тухай хууль
23		Ашиглалтын талбайд гидрогеологийн нарийвчилсан судалгаа хийлгэх.	Төслийн хүрээнд	-	-	-	Ажил гүйцэтгэлийн гэрээний үндсэн дээр	2024-2028 он	Усны тухай хууль
25	Машин механизмын шатахуун, түлш, тос асгарах /ШТМ/, улмаар хөрсөөр нэвчин гүний усны чанар стандарт өөрчлөгдөх	Уурхай ажил явагдах нийт хугацаанд ШТМ болон хорт хаягдал асгарахаас сэргийлэх тэдгээрийг ил задгай хаяхгүй байх ШТМ хөрсөнд шууд асгарсан тохиолдолд түүнийг	Төсөл хэрэгжиж буй нийт АМТЗ бүхий талбай болон түүний ойр орчмын талбайн хэмжээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он тухай бүрт	Усны тухай хууль

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
		саармагжуулах, зайлуулах арга хэмжээг авч ажиллах							
26	Шүүрлийн ус шавхалтаас газрын доорх усны горим, нөөцөд сөргөөр нөлөөлж усны түвшин буурч болзошгүй	Ил уурхайн дэргэд газрын доорх усны түвшин, чанарын өөрчлөлтийг хянах мониторингийн цооног байгуулах, тогтмол хэмжилт дээжлэлт хийж байх	Уурхайн ухшийн дэргэд	-	-	1-2	4 750.0	2024 он	Усны тухай хууль БОАЖ, ЭМСайдын 2009 оны 51/75 дугаар тушаал MNS ISO 5667-1:2002
		Шүүрлийн усыг татан зайлуулж хөв цөөрөм байгуулах. Усны мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх.	Төслийн талбайд	-	5 000.0	-	5 000.0	2024 он	
	Төслийн хэрэгцээнд ашиглах боломжит усны нөөцөөс хэтрүүлэн хэрэглэж багийн төвийн хүн амын усан хангамжид сөрөг нөлөө үзүүлж болзошгүй	Төслийн хэрэгцээнд ашиглаж буй усны зарцуулалтыг хэмжих зорилгоор ашиглаж буй усны эх үүсвэрт мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан тоолуур тавих	Гүний худаг шүүрлийн ус татах хэсэгт	Ширхэг	100.0	2	200.0	2024 он	Усны тухай хууль БОНХС-ын А-156-р тушаал “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
Ургамал ба амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах									
29	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлан нөмрөг устах	Барилга байгууламж, ажилчдын хотхоны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор мод сөөг тарьж ургуулах	Ажилчдын хотхон, барилга байгууламжийн гадна талбайд	-		-	1000.0	2024 он	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
31	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх	Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавих, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжийг сайжруулах зэргээр биотехнологийн арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран зохион байгуулах	Төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар нутгийн орчимд	-	-	-	100 боодол өвс, 1 тонн хужир 1000.0		Амьтны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль
		Нийт					14 450.0		

5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Ашиглалтын талбайд одоогоор нөхөн сэргээх орон зай үүсээгүй байна.

Хүснэгт 2. Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

